



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 80

Мөрөн

Ээлжит хуралдаан товлон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын ээлжит XIII хуралдааныг 2015 оны 12 дугаар сарын 03 -ны өдрийн 10.00 цагт Мөрөн сумын төвд хуралдуулахаар товлон зарласугай.

2. Аймгийн ИТХ-ын ээлжит XIII хуралдаанаар доорх асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны үйл ажиллагааны тайлан

2. Аймгийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, үр дүн, цаашдын зорилт

3. Аймгийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд ИТХ-ын дэргэдэх хороод, иргэний нийгмийн байгууллагын зөвлөлөөс хийсэн дүгнэлт

4. Аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2015 оны үндсэн чиглэлийн биелэлт, 2016 оны үндсэн чиглэлийн тухай

5. Аймгийн 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны төсвийн өнөөгийн байдал, 2016 оны төсвийн төслийг батлах тухай

6. Аймгийн 2016 оны төсвийн төсөлд өгөх аймгийн Аудитын газрын дүгнэлт

7. Аймгийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай

3. Хуралдааны бэлтгэлийг бүрэн хангах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг аймгийн /ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг түр орлон гүйцэтгэгч/ С.Цогтоо, /Засаг даргын тамгын газрын дарга/ Г.Төмөрбаатар нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БОЛДБААТАР